

“АБТС ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны
06 сарын 06-ны өдрийн хурлын 1 дүгээр тогтоолын хавсралт 18



“АБТС ББСБ” ХХК-ИЙН ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНЛЭСЛЭЛ

- 1.1. “АБТС ББСБ” ХХК /цаашид “ББСБ” гэх/, Хувьцаа эзэмшигч /цаашид “ХЭ” гэх/-ийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг ББСБ-ын ХЭ, харилцагч болон нэмэгдэл сонирхолтой этгээдийн эрх ашигт нийцүүлэх, зохистой засаглалын тогтолцоог боловсронгуй болгоход энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. ББСБ-ын зохистой засаглалыг хэрэгжүүлэхдээ Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, журмыг удирдлага болгоно.
- 1.3. Энэ журамд хэрэгдэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 1.3.1. **Хувьцаа эзэмшигч** – Компанийн тухай хуулийн 3.2-т тодорхойлсон хувьцааг эзэмшсэнээр 3.3-т заасан эрх эдэлдэг этгээд
 - 1.3.2. **Харилцагч** – Иргэний хуулийн 445.1-д заасны дагуу төлбөр тооцооны гэрээгээр ББСБ-аар гүйцэтгүүлж буй этгээд
 - 1.3.3. **Нэгдмэл сонирхолтой этгээд** – Компанийн тухай хуулийн 89.2-т тодорхойлсон этгээд
 - 1.3.4. **Сонирхлын зөрчилтэй хэлцэл** – Компанийн тухай хуулийн 89-т тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээд 89.1-д заасан харилцаанд оролцсоныг.

ХОЁР. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

- 2.1. ХЭ нь ББСБ-ын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой Компанийн тухай хуульд заасан мэдээллийг зөвхөн ТУЗ-өөр дамжуулан гаргуулан авах эрхтэй.
- 2.2. ТУЗ-ийн гишүүний ажлын хөлс, урамшуулал нөхөн олговор, тэтгэмж, аливаа хөнгөлөлттэй холбоотой асуудлыг ТУЗ-ийн гишүүнтэй байгуулах хөдөлмөрийн гэрээнд тодорхой тусгах эрхтэй.
- 2.3. ХЭ нь ББСБ-д зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд Компанийн тухай болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:
 - 2.3.1. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг мэргэжлийн түвшинд сонирхлын зөрчилгүй, хараат бус байдлаар шийдвэрлэх чадвартай ТУЗ-ийн гишүүнийг томилох
 - 2.3.2. ХЭ нь холбогдох болон нэгдмэл сонирхолтой этгээдийн талаарх мэдээллийг холбогдох баримт материалын хамт ББСБ-ын ТУЗ-ийн нарийн бичгийн даргад тухай бүр ирүүлэх
- 2.4. ХЭ нь ББСБ-ын үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно.
 - 2.4.1. Хувийн ашиг сонирхлын үүднээс эрх мэдлээ хэтрүүлэх, урвуулан ашиглах.

ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 3.1. ТУЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна.
- 3.2. ТУЗ нь түүний дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журамыг батлах

- 3.3. Гүйцэтгэх удирдлага болон бусад шийдвэр гаргах шатны эрх бүхий албан тушаалтнаас дараах тайлбар гаргуулан авах
 - 3.3.1. Холбогдох хууль тогтоомжид заасан зохистой харьцаа, хязгаарлалтыг зөрчиж хийсэн ажил гүйлгээ
 - 3.3.2. ББСБ-ын хяналтын багцыг эзэмшдэг ХЭ, ББСБ-ын эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн холбогдох этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл, үүнтэй холбоотойгоор үүссэн эрсдэл
 - 3.3.3. ХЭ-ийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлаас бусад ББСБ-ын гүйцэтгэх удирдлагад хяналт тавьж ажиллана.
- 3.4. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, тэдгээрийн ажиллах журмыг батлах
- 3.5. Гүйцэтгэх удирдлага болон бусад шийдвэр гаргах шатны эрх бүхий албан тушаалтнаас тайлбар гаргуулан авах
 - 3.5.1. Холбогдох хууль тогтоомжид заасан зохистой харьцаа, хязгаарлалтыг зөрчиж хийсэн ажил гүйлгээ
 - 3.5.2. ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын тогтвортой байдалд ноцтой үзүүлэх ажил гүйлгээ
 - 3.5.3. ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын тогтвортой байдалд ноцтой нөлөө үзүүлэх ажил гүйлгээ
- 3.6. ББСБ-ын гүйцэтгэх удирдлагад хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг хагас жилд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, ХЭ-дэд эрх тэгш хандах
- 3.7. ХЭ, харилцагч болон нэгдмэл сонирхолтой этгээдийн эрх ашгийг хамгаалах
- 3.8. ББСБ-ын бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлох, ББСБ-д үр ашигтай шийдвэр гаргах
- 3.9. ББСБ-ийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн талагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт% ББСБ-ын бүтцийн өөрчлөлт зэрэг гүцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих
- 3.10. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээнд, эрх үүрэг хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах тогтолцоог бүрэн тусгаж, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэх
- 3.11. ББСБ-ын удирдлагыг сонгон шалгаруулах, тэдгээрийн залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөнд удирдах дээд албан тушаал бүрт тавигдах ажил мэргэжлийн шаардлага, чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хангалттай түвшинд бэлтгэхийг тодорхой тусгасан байх
- 3.12. Гүцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг ББСБ-ын эрхэм зорилго, урт хугацааны хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон гэрээнд заасан үүргийн биелэлт зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх
- 3.13. ББСБ-ын дүрмээр болон хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажилүүргээ хариуцлагатай, үнэнч шударгаар гүйцэтгэж, чанлан сахих
- 3.14. Ашиг сонирхлын зөрчлийн улмаас ББСБ-ын өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх
- 3.15. Олон улсын болон МУ-ын хууль тогтоомж стандартад заасан шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийгэх
- 3.16. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах
- 3.17. ТУЗ нь ББСБ-ын үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хоригдоно:
 - 3.17.1. ТУЗ-ийн гишүүд болон түүнийг төлөөлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн ББСБ-д зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, төлбөр нь

- чанаргүйд ангилагдсан тохиолдолд тус гишүүнийг ТУЗ-ийн хуралд саналын эрхтэй оролцуулах
- 3.17.2. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд ТУЗ-ийн үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:
- 3.17.2.1. Аудит болон эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнд саналын эрхтэйгээр орж ажиллах
- 3.17.2.2. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин урамшууллын хэмжээг тогтоох
- 3.17.2.3. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх
- 3.18. ТУЗ-ийн дарга зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд хуульд зааснаас гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ:
- 3.18.1. Тухайн асуудлаар шийдвэр гаргахад ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүнэлтийг үндэслэх
- 3.18.2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаанд хяналт тавих
- 3.18.3. ТУЗ-ийн гишүүнийг зохистой засаглалын сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийг батлан гаргаж, хэрэгжүүлэх
- 3.19. Хараат бус гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн гишүүний ажлын хөлс, урамшууллын хэмжээнээс багагүй байна.
- 3.20. Хараат бус гишүүн нь холбогдох хуульд зааснаас гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ:
- 3.20.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь тухайн ББСБ-ын эрх өшигт сөргөөр нөлөөлөх эсэхэд хяналт тавих
- 3.20.2. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих ББСБ-ын харилцагчийн эрх ашгийг хамгаалах
- 3.20.3. ББСБ-ын харицлагчийн эрх ашгийг хамгаалах
- 3.20.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэл, их хэмжээний хэлцэлийг хэлэлцэхэд заавал оролцож санал өгөх
- 3.20.5. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь ББСБ-ын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах шаардлагыг эс биелүүлэх тохиолдолд уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар ХУ-ийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх
- 3.20.6. Хараат бус гишүүн Аудитын болон Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнд заавал орж ажиллах
- 3.21. ТУЗ нь эрх үүргээ хэрэгжүүлэх үүднээс хороодыг байгуулж, хороод нь дараах чиг үүргийн дагуу тухайн асуудлар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна:
- 3.21.1. Эрсдэлийн удирдлагын хороо:
- 3.21.1.1. ББСБ-ын эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих
- 3.21.1.2. ББСБ-ын гүйцэтгэх удирдлагын зүгээс зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн болон бусад төрдийн эрсдэлийн талаар авч хэрэгжүүлэх буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавих
- 3.21.1.3. Санхүүгийн хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан эсэхэд хяналт тавих
- 3.21.1.4. Бусад холбогдох асуудал
- 3.21.2. Аудитын хороо:

- 3.21.2.1. Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-д танилцуулж буй санхүүгийн тайлан, мэдээ нь үнэн зөв, бүрэн гүйцэд боловсруулсан эсэхэд хяналт тавих
- 3.21.2.2. Аудитын бодлого, дүрэм журмын хэрэгжилт, аудитын төлөвлөгөөний биелэлт болон шалгалтын удирдамжийн агуулгад хяналт тавих
- 3.21.2.3. Хөндлөнгийн болон дотоод аудитын асуудлыг хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хариуцан ажиллах
- 3.21.2.4. Хөндлөнгийн болон дотоод аудитын тайлан, аудитуудын ажлын гүйцэтгэл, тайланг хугацаанд нь үнэн зөв ирүүлж байгаа эсэхэд хяналт тавина
- 3.21.2.5. Хөндлөнгийн болон дотоод аудитын тайлантай асуудлыг ТУЗ-д танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулах
- 3.21.2.6. Дотоод аудитуудыг сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих
- 3.21.2.7. Бусад холбогдох асуудал
- 3.21.3. Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо:
 - 3.21.3.1. ББСБ-д мөрдөгдөж буй цалин урамшууллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих
 - 3.21.3.2. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад олгох цалин урамшууллын хэмжээг тодорхойлох
 - 3.21.3.3. Гүйцэтгэх удирдлагын урамшууллын асуудлыг ББСБ-ын эрхэм зорилго, стратегий төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн хэм хэмжээ болон ББСБ-ын урт хугацааны ашигт ажиллагаатай уялдуулсан эсэхэд хяналт тавих
 - 3.21.3.4. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг идэвхжүүлэх
 - 3.21.3.5. Бусад холбогдох асуудал

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 4.1. ББСБ-ын гүйцэтгэх удирдлага гэдэгт гүйцэтгэх захирал, дэд захирал болон ББСБ-ын газар нэгжийн захирлыг хамруулна.
- 4.2. Гүйцэтгэх удирдлага нь ББСБ-д зохистой засаглалын зарчим хэрэгжүүлэхэд холбогдох хуульд заасан үүргээс гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ:
 - 4.2.1. ББСБ-ын стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөө, жилийн төсөв, бүтэц зохион байгуулалт болон үйл ажиллагаанд мөрдөж ажиллах бодлого, дүрэм, журам, зааврыг боловсруулж, ТУЗ-өөр батлуулах
 - 4.2.2. ТУЗ-өөс баталсан төлөвлөгөө, бодлого, дүрэм, журам заавар, стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, мөрдүүлэх
 - 4.2.3. ББСБ-ын ажилтныг албан үүргээ сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй гэж үзвэл гүйцэтгэх удирдлагад бичгээр мэдэгдэх тогтолцоог бүрдүүлэх
 - 4.2.4. ББСБ-ын эрсдэлд тогтмол хяналт тавьж, зохистой түвшинд барих талаар санаачилга гарган ажиллах, эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон хязгаарлалт, СЗХ-ноос тогтоосон ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт алдагдсан тохиолдолд зохих арга, хэмжээг авч хэрэгжүүлэх
 - 4.2.5. ББСБ-ын үйл ажиллагааны онцлог болон учирч болзошгүй эрсдэлийн түвшинтэй уялдуулан удирдлагын мэдээллийн системийн үйл ажиллагаа болон түүний аюулгүй байдлыг хангах хяналтын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

- 4.2.6.ББСБ-ын харилцагчийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих
- 4.2.7.ББСБ-ын хувьцаа эзэмшигч болон ТУЗ-өөс гаргасан шийдвэр нь хууль тогтоомжийг зөрчих, ББСБ-ын үйл ажиллагаанд ноцтой эрсдэл учруулах магадлалтай бол ББСБ-ын гүйцэтгэх удирдлага нь уг үүргийг биелүүлэхээс татгалзах эрхтэй бөгөөд энэ талаар мэдэгдэх
- 4.2.8.Харилцагч болон ББСБ-ын бусад холбогдох этгээдийн эрх ашиг хөндөгдсөн тохиолдол бүрт ТУЗ-д мэдэгдэх
- 4.2.9.ТУЗ нь гүйцэтгэх захирал болон ББСБ-ын үйл ажиллагаанд байнга хяналт тавьж ажиллана.

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 5.1. ТУЗ, Гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын нэгжийг бие даасан хэлбэрээр зохион байгуулж, ББСБ-д учирч болох эрсдэлийг удирдах, хянах тогтолцоог бүрдүүлэх ба эрсдэлийн удирдлагын нэгжийн ажилтны эрх үүрэг, шийдвэр гаргах эрх мэдэл, хариуцдагын тогтолцоо болон тайлагнах зарчмыг нарийвчлан тогтооно.
- 5.2. Эрсдэлийн удирдлагын нэгж нь ББСБ-д учирч болох эрсдэлийг нээн илрүүлэхэд шаардагдах ББСБ-ын дотоод мэдээллийн системд нэвтрэх эрх, хүн хүч, хөрөнгө нөөц, үнэн зөв, бүрэн гүйцэт мэдээллээр хангагдсан байна.
- 5.3. Эрсдэлийн удирдлагын нэгж нь ББСБ-ын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, түүний хэрэгжилт болон эрсдэлийн ерөнхий түвшингийн талаар ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хороонд тодорхой хугацаанд давтамжтайгаар тайлагнана.
- 5.4. Эрсдэлийн удирдлагын нэгжийн удирдах албан тушаалтан тухайн эрсдэлийн ББСБ-д учруулах үр дагаварыг үнэлэх, дүгнэх чадвартай байна.
- 5.5. Эрсдэлийн удирдалын чиг үүргийг дараах үе шаттай хэрэгжүүлнэ
 - 5.5.1.ББСБ-д учирч болох эрсдэлийн төрлийг тодохойлох
 - 5.5.2.Төрөл тус бүрт харгалзах эрсдэлийн түвшинг тодорхойлох
 - 5.5.3.Шаардагдах хөрөнгийн хэмжээг тодохойлох
 - 5.5.4.Эрсдэл хүлээх шийдвэр нь ТУЗ-өөс баталсан бодолго болон бусад бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэхийг хянах
 - 5.5.5.Эрсдэлийн үр дагаварыг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад тайлагнах
- 5.6. Эрсдэлийн удирдлагын нэгж нь учирч болох эрсдэлийг нэгдэл, охин, хараат компаниуд, салбар нэгж, ББСБ-ыг бизнесийн чиглэл, бүтээгдэхүүн тус бүрээр болон нэгдсэн байдлаар тогтоож, дүн шинжилгээ хийнэ.
- 5.7. Томоохон харилцагчийн үйл ажиллагааны онцлог, салбар нэгж болон бизнесийн чиглэл бүрээр эрсдэлийг үнэлнэ.
- 5.8. ББСБ-ын зээлийн хөрвөх чадвар, хууль эрх зүй, нэр хүндийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлж улмаар нэгж тус бүрт учирч болох эрсдэлийг шинжилж, дүгнэлт гаргаж, шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавина.
- 5.9. ББСБ-ын үйл ажиллагааны чиглэл тус бүрээр газар, хэлтсийн хооронд мэдээлэл солилцох, мэдээллийн хэвтээ бүтэц, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр хангах, мэдээллийн босоо бүтцийг бүрдүүлсэн байна.

ЗУРГАА ДОТООД АУДИТ

- 6.1. Дотоод аудитын нэгж нь ББСБ-д зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд дараах үүргийг хэрэгжүүлж, үнэлэлт дүгнэлт өгнө:
 - 6.1.1. Эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг боловсруулах
 - 6.1.2. Дотоод аудитын тайлангаар өмнө гарсан зөрчил, дутагдлыг хэрхэн биелүүлж байгаад эргэн хяналт тавих
 - 6.1.3. ТУЗ-өөс баталсан бодолго дүрэм, журам, зөвлөмжийг ББСБ-ын гүйцэтгэх удирдлага биелүүлж байгаа эсэхэд
 - 6.1.4. ББСБ-ын зохистой засаглал, санхүү тайлагнал, дотоод хяналт, мэдээллийг систем болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь тогтоосон хэм хэмжээний хүрээнд явагдаж байгаа эсэхэд
 - 6.1.5. Гүйцэтгэх удирдлагаас хувьцаа эзэмшигч болон ТУЗ-д хүргүүлжбуй тайлан мэдээ нь үнэн зөв эсэхэд
 - 6.1.6. ТУЗ болон Гүйцэтгэх удирдагын хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар ажиллах
 - 6.1.7. ББСБ-ын үйл ажиллагааны эрсдэлийн түвшин, гүйцэтгэх удирдлагаас эрсдэлийг бууруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь гэрээ хэлцэл, хүлээж болзошгүй алдагдлын хэмжээтэй уялдаж байгаа талаар
 - 6.1.8. ББСБ-ын эрхлэх үйл ажиллагаа, тэдгээрт харгалзах эрсдэл, нөлөөлөх хүчин зүйлсийн талаар аудитын дүгнэлтэд тусгаж, хяналт шалгалт нь ББСБ-д учирч болох эрсдэлийг нээн илрүүлэхэд чиглэсэн байх
 - 6.1.9. ББСБ-ын үйл ажиллагааны нэгж тус бүрт үүсэх эрсдэлийг илрүүлэх, хүлээж болзошгүй алдагдлын хэмжээ болон шаардагдах хөрөнгийн талаар судалгаа, шинжилгээ хийж удирдлагад танилцуулж, тайлагнасан байдалд
 - 6.1.10. ББСБ-аас зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах тохиодолд учирч болох эрсдэлийн талаар дүн шинжилгээнд
 - 6.1.11. ХЭ, ТУЗ болон эрх бүхий байгууллагаас гүйцэтгэх удирдлагад тавьсан шаардлагыг биелүүлсэн эсэхэд
 - 6.1.12. ББСБ-ын үйл ажиллагаанд үнэлэлт өгч, шалгалтын акт материал, хэрэгжүүлэх арга хэмжээний төслийг боловсруулан ТУЗ-ийн дэргэдэх хороодод тухай бүр танилцуулах
 - 6.1.13. ББСБ-ын зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн талаар үнэлгээ, дүгнэлт гаргах.

ДОЛОО. ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ

- 7.1. ББСБ-д зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлэхг түүний хэрэгжилтийг хангахад холбогдох хуульд заасан шаардлагаас гадна дараах мэдээллийн ББСБ-ын цахим хуудсаар тайлагнана.
 - 7.1.1. ББСБ-ын эрхэм зорилго, хэтийн зорилт
 - 7.1.2. ББСБ-ын хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн, хэрэд ХЭ нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчөөр
 - 7.1.3. ББСБ-ын толгой болон салбар компаниуд, түүний үйл ажиллагааны талаар

- 7.1.4.ББСБ-ын нөлөө бүхий ХЭ, ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, түүний орлогч ББСБ-ын нэгжийн удирдлага, хяналтын зөвлөлийн гишүүдийн нэрс, мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага туршлагын талаар
- 7.1.5.ББСБ-ын холбогдох этгээдэд олгосон зээл, түүнтэй адилтган үзэх актив хөрөнгийн талаарх мэдээллийг зээлдэгч, олгосон зээл, өөрийн хөрөнгөд эзлэх хувь зэргээр дэлгэрэнгүй байдлаар
- 7.1.6.ББСБ-ын бүтээгдэхүүх, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл
- 7.1.7.ТУЗ, гүйцэтгэх удирдлагаар баталгаажуулсан жилийн тайланд ББСБ-ын нийгмийн хариуцлагын талаар